



ТАВАНТОЛГОЙ-ГАСУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН
ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ"-ИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.БУДБАЯР



**“ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ”-
ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

БАЙРШИЛ: ӨМНӨГОВЬ АЙМАГ, ЦОГТЦЭЦИЙ, БАЯН-ОВОО, ХАНБОГД СУМ

РЕГИСТРИЙН ДУГААР: 6375405

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН..... /...../

БОЛОВСРУУЛСАН:

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, ОРОН НУТГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

/Д.ТЭМҮҮЛИН/

2024 ОН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	5
2.1 Төслийн талбайн байршил.....	5
2.2 Нийгэм, эдийн засгийн ерөнхий төлөв.....	6
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	7
3.1 Газрын гадарга, хэвлий.....	7
3.2 Агаарын чанар.....	9
3.3 Уур амьсгал.....	9
3.4 Гадаргын болон газрын доорх ус.....	9
3.5 Ургалан нөмрөг.....	11
3.6 Амьтны аймаг.....	11
3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг.....	13
3.8 Дуу шуугиан.....	15
3.9 Нийгэм, эдийн засаг.....	15
3.10 Түүх, соёлын дурсгалт газар.....	15
3.11 Хаягдлын менежмент.....	15
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	16
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	16
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	27
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажил 2012-2015 оны хугацаанд ПК0+000-ПК208+500 хүртэл газар шорооны ажлын 86.6%, гүүр хоолойн ажлын 52%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж 2018 оны УИХ-ын шийдвэр гарах хүртэл хугацаанд түр хойшлогдон зогсолтын байдалд ороод байсан юм. Харин УИХ-ын 2018 оны “Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолоор Тавантолгой нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан. Энэхүү тогтоолын хүрээнд Засгийн газрын 2018 оны 242, 2019 оны 304 дүгээр тогтоолоор тус төслийн ажлыг эрчимжүүлсэн байна.

Тус төмөр зам нь уулзваргүй, 1-р зэрэглэлийн, 25 тонны даацтай, хоёр өртөө, зургаан зөрлөгтэй ба 15 гүүр, 174 хоолой, 21 мал, амьтны гарц, гарамтай.


“Тавантолгой төмөр зам” ХХК нь Таван толгой уурхайгаас Гашуунсухайт хилийн боомт хүртэл 248.5 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2020 оны нэгдүгээр улирлаас эхлүүлэн гүйцэтгэж 2022 онд төмөр замыг ашиглалтад оруулсан. Энэхүү төмөр зам ашиглалтад орсноор Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл болно. Тавантолгой нүүрсний бүлэг ордоос олборлох нүүрс ба бүс нутгийн бусад (Оюутолгой г.м) уул уурхайн бүтээгдэхүүн бараа материалыг тээвэрлэх тээвэрлэлт жилдээ 2-3 дахин нэмэгдэж, уурхайн олборлолт 30 орчим сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг экспортлох тооцоо гарсан байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих, ашиглах төслийн 2020-2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ. БОХТ буюу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан. ОХШХ-т нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон оруулсан.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбайн байршил

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн трасс 248.5 км үргэлжилнэ. Уг трасс нь Өмнөговь аймгийн Цогтцэций (Сийрст баг), Баян-Овоо (Могой баг), Ханбогд (Жавхлант баг) сумдын нутгийг дайран өнгөрөх бөгөөд үүнээс Цогтцэций сумын нутаг дэвсгэрт 55.13 км, Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт 82.79 км, Ханбогд сумын нутаг дэвсгэрт 110.58 км урттай төмөр зам баригдахаар төлөвлөгдсөн байна. (Зураг 1-ээс дэлгэрэнгүй харах).



Зураг 1. Төслийн ерөнхий байршил

Хүснэгт 1. Трассын сумдад харгалзах талбайн хэмжээ

№	Аймаг, сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, км.кв	Трасс дайран өнгөрөх км	Эзлэх хувь, %
1	Цогтцэций	7246,4	55.13	0.76
2	Баян-Овоо	10473,7	82.79	0.79
3	Ханбогд	15151,6	110.58	0.72
Нийт		32871,7	248.5	2.27

2.2 Нийгэм эдийн засгийн ерөнхий төлөв


Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд хэсэгт 165.4 мян.км² газар нутгийг эзлэн Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудтай хиллэнэ. Аймгийн төв Даланзадгад нь Улаанбаатар хотоос 575 км, Дундговь аймгийн төв Мандалговиос 300 км зайтай оршдог. Судалгааны бүс нутаг нь Өмнөговь аймгийн зүүн хэсэгт, аймгийн нийт нутаг дэвсгэрийн 19.8 хувийг эзлэх 32.8 мян.км² газар нутгийг хамрах бөгөөд засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Цогтцэций /Сийрст, Билгэх, Цагаан-Овоо, Өгөөмөр багуудтай/, Баян-Овоо /Могойт, Харзаг, Налих багуудтай/, Ханбогд /Номгон, Гавилууд, Жавхлант, Баян, Хайрхан багуудтай/ сумдын нутгийг хамарна. Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутагт Тавантолгойн уурхай, Ханбогд сумын Жавхлант багийн нутагт Оюутолгойн уурхай, Хайрхан багийн нутагт Цагаанхад суурьшлын бүс тус тус оршино.

Хүснэгт 2. Трассын дайран өнгөрч буй сумдын ерөнхий үзүүлэлтүүд

№	Аймаг, сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, км.кв	Хүн амын тоо 2020 он	Хүн амын нягтшил 2020 он	Өрхийн тоо 2020 он	Малчин өрхийн тоо 2020 он
1	Баян-Овоо	10473,7	1 716	0.2	594	331
2	Ханбогд	15151,6	7798	0.6	2,031	389
3	Цогтцэций	7246,4	7 692	1.2	2,573	312

Эх сурвалж: УСГ, www.1212.mn

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутгаар дайран өнгөрч байна. Цогтцэций сумын Сийрст багийн нутгаар 52.1 км, Баян-Овоо сумын Могойт багаар 78.8 км, Ханбогд сумын Жавхлант багаар 72.9 км тус тус дамжин өнгөрч байна. Цогтцэций суманд Таван толгой нүүрсний бүлэг ордууд, Ханбогд суманд Оюу толгойн зэс алтны ордууд байрладаг бол Баян-Овоо суманд томоохон ашиглалтад орсон орд байхгүй байна.



Зураг 2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн засаг захиргааны хуваарийн зураг

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төмөр зам нь шугам сүлжээний газарт хамрагдах бөгөөд төмөр замын далан, хамгаалалтын бүс, гал тэрэгний өртөө, зөрлөгийн барилга зэрэг байгууламжаас бүрдэнэ. Төмөр замын трассаас тийш 1 км-ийн радиуст орчны бүсийг үүсгэхэд нийт 49360 га нутаг хамрагдаж байна. Энэхүү төмөр замын ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдээр тодорхойлов. Үүнд:

3.1 Газрын гадарга, хэвлий. Төмөр замын ашиглалтын үед шатах тослох материал алдагдах, хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээс хог хаягдлаар бохирдох, ашиглалт явуулсан түгээмэл тархацтай ашигт малтмалын эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийгдээгүйгээс газрын гадарга эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй. Тус талбай нь хойноосоо урагш уртрагийн дагуу сунаж тогтсон учир хотгор гүдгэрийн хувьд дундаж өндөр, нам уулс, цав толгод, хөндий хотгор хосолсон бөгөөд ерөнхийдөө долгиорхог тэгш гадаргатай.

3.2 Агаарын чанар. Төмөр замын ашиглалтын үед засвар үйлчилгээнд ашиглах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр түр зам, талбайгаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Вогоны зүтгүүрээс ялгарах нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад бага хэмжээгээр нөлөөлнө.

3.3 Уур амьсгал. Вогон зүтгүүрээс ялгарах хүлэмжийн хийн гол бүрэлдэхүүн болох нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ.

3.4 Гадаргын болон газрын доорх ус. Талбайд ажиллах тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед болон ажилчдын санамсар болгоомжгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гэнэтийн осол гарч шатах тослох материал асгарсан тохиолдолд хөрс бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын түр урсац болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ус хангамж болон ногоон байгууламжийн усалгаанд 18 худаг ашиглана. Ашиглалт явуулж буй бүх худгуудад тоолууртай байх бөгөөд ус ашиглуулах дүгнэлтийг Усны газраар гаргуулж, Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаатай гэрээ байгуулан хамаарах сумдын Засаг даргын тамгын газраас ус ашиглах эрхийн бичиг авч ажиллана.



Зураг 4. Худгийн мэдээлэл

3.5 Ургамлан нөмрөг. Төмөр замын дагуу 2 өртөө, 6 зөрлөг орчим суурьшлийн бүс үүсч тухайн хэсэг газрууд нөлөөлөлд өртөнө. Өмнөх жилүүдийн бүтээн байгуулалтын ажлын явцад нөлөөлөлд өртсөн талбай, газруудыг “Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө”-ний дагуу холбогдох стандартын дагуу нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.6 Амьтны аймаг. Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т болон 2015 онд батлагдсан MNS 6515:2015 (Тал хээрийн бүсийн авто болон төмөр зам дагуу нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц) стандартыг баримтлан трассын дагуух гарц, гармуудад хөдөлгөөн мэдрэгч автомат камер суурьлуулж зэрлэг ан амьтадын шилжилт хөдөлгөөнийг бүртгэлжүүлэн ажиллах тул бэлчээрийн болон зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулах эрсдэл багасна.




Зураг 5. Трассын дагуу байгуулсан мал амьтны гарц гармуудын байршил

3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг. Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй тул тэдгээр газруудад шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй. Харин төмөр замын трассын хил холболтын ПК208+500 дахь км-ээс хил холболт хүртэлх 32 км-ын 13 км нь Говийн бага дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүс ба хязгаарлалтын бүс дотор орж байна.

Говийн бага дархан цаазат газар нь говийн аймгуудын зааг нутгийг хамрах тул ерөнхийдөө зэлүүд ба хилийн дагуух нутгийг хамгаалах, судлахад чухал ач холбогдолтой. Говийн их дархан газар нь цөлийн ландшафтыг төлөөлдөг. Харин жинхэнэ говийн ландшафт бүхий энэ нутгийг хамгаалалтад авснаар говийн эмзэг экосистемийг хамгаалах, судлах, зүй зохистой ашиглахад чухал ач холбогдолтой.

Тухайн төмөр замын трасс нь хязгаарлалтын бүсэд баригдаж байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй.



Зураг 6. Говийн бага дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүс

3.8 Дуу шуугиан. Төмөр замын ашиглалтын үед гарах дуу шуугианы хэмжээ нь MNS 5002:2000 стандартад нийцсэн хэмжээгээр буюу 65-85 дБ байх ба тус төмөр зам нь 1-р зэрэглэлийнх буюу уулзваргүй төмөр зам тул сөрөг нөлөөлөл бага.

3.9 Нийгэм, эдийн засаг. Төмөр замын трасс газартай өвөлжөө хаваржааны газар нь давхцсан болон төмөр замын аюулгүйн бүс, нөлөөллийн бүст багтсан тус бүр (3) айлуудыг нүүлгэн шилжүүлж, нөхөн төлбөрийг олгож, хамаарах сумдын ЗДТГ-аас газрыг шилжүүлэн олгосон. Мөн бэлчээр хуваагдсан өрхүүдэд мал, амьтан гаргах нүхэн гарц байгуулан өгч, гар худгуудыг сэргээн засварлаж өгсөн тул сөрөг нөлөөлөл үүсэх эрсдэл бага байна.

3.10 Түүх, соёлын дурсгалт зүйлс. Төмөр замын ашиглалтын үед түүх, соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Гурван зээрдийн дурсгалт газрыг 2022 онд тохижуулсан. 2024 онд орчны бохирдлыг цэвэрлэх, тохижилтыг сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.



Зураг 7. Гурван Зээрдийн агуйн зураг

3.11 Хаягдлын менежмент. Төмөр замын ашиглалтын үйл ажиллагааны явцад аюултай болон ахуйн хог хаягдлууд үүснэ. Энэ нь санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хаягдал асгарч алдагдсанаас болж хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй.

Байгаль орчны менежмент нь төсөл хэрэгжих явцад бий болох хог хаягдлуудын хэмжээг багасгах, ангилан зайлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох болон менежментийн техникүүдийг шинээр тусган хэрэгжүүлэх замаар хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ.

Төмөр замын барилга, байгууламжуудын үйл ажиллагааны үед бий болох хаягдал, тэдгээрийн устгал, зайлуулалтын улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг бууруулах хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх замаар үр ашигтай зохион байгуулж, бууруулж болно. Энэ нь төслийн байгаль орчны менежментийн чухал хэсэг болно.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төслийн БОМТ-ний гол зорилтуудыг 2012 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2017 оны 5 дугаар сард УИХ баталсан Хог хаягдлын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн баталж гаргасан журам, стандарт, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн тус төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам” зэрэгт үндэслэн тодорхойлов.

Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618-журмын 2.15 дахь заалт). Дэд бүтцийн төслийн бүтээн байгуулалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгана (А/618-журмын 2.17 дахь заалт).

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана (БОНБУ-ний тухай хуулийн 9.9 дахь заалт).

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Энэхүү төмөр замынтээжрийн үйл ажиллагаанч явцад 2024 онд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал урьдчилсан байдлаар 77,643,500 (далан долоон сая зургаан зуун дөчин гурван мянга таван зуу) төгрөг. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д/д	Авах арга хэмжээний нэр	Зардал, төгрөг
		2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12,803,500
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	50,000,000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	700,000
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	480,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9,960,000
6	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	3,700,000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	-
2024 оны нийт зардал, төгрөг		77,643,500.0

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг Монгол Улсын байгаль орчны багц хуулиудаар тавигдсан шаардлага, БОАЖЯ-ны 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, БОННУ-ний хүрээнд боловсруулсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардлагуудыг үндэслэн тодорхойлов.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Төслийн ажилд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Төсөлд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмын үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Төмөр замын ашиглалтын үйлчилгээнний машин механизм, техник хэрэгсэл	ш	19	34,500	655,500	жилд 1 удаа	MNS 5013:2003 MNS 5014:2003
Барилгын ажлын талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайг усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах	Барилгын ажил хийгдэж буй бүх зам талбай	м ³	10,000	199,8	1,998,000	хуурайшилтын улиралд өдөр бүр бусад үед цаг уурын нөхцөлөөс хамаарна	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007
Дүн						2,653,500		
2. ХӨРС БА УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								

Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө.	Төмөр замын дагуу ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлэх	Гашуунсухайт ачилт буулгалтын хэсэгт, Тавантолгой өртөө	ш	20	140,000	2,800,000	(ашиглалтын явцад тодорхой төлөвлөгөөний дагуу арчилж тордож нэмэгдүүлж байх)	“Газрын тухай” хууль 50 дугаар зүйл MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.
Дүн						2,800,000		
3. ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Усан хангамжид ашиглах бүх худгуудыг тоолууржуулах	худгууд	ш	3	450,000	1,350,000	Тоолуурууд гацсан гэмтсэн болон шинээр эх үүсвэр ашиглах болсон тухай бүр солих арга хэмжээ авах,	MNS0900:2018- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

Усыг их хэмжээгээр ашигласнаас усны түвшин буурах, ундарга багасах	Төмөр замын ус хангамжийн худгуудын ойролцоох худгуудад түвшин бууралт ашиглагдаж буй эсэхийг шалгах зориулалтаар хэмжилт хийх	Гашуунсухайт, Тавантолгой өртөөнд ашигласан худгуудын ойролцоо цооногууд	ш	2 /Нийт 4 удаа/	Дотоод үйл ажиллагааны зардлаас		Жилдээ 2 удаа	Усны тухай хууль
Дүн						1,350,000		
4. АМЬТНЫ АЙМАГ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Төмөр замын үйл ажиллагаанаас нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулах Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Зэрлэг амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ авах	Төмөр замын трассын дагуу (Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын 5 байршилд)	ш	300	20,000	6,000,000	Жилдээ 1 удаа	Амьтны тухай хууль MNS 6515 : 2015 (Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц)
Дүн						6,000,000		
Нийт дүн						12,803,500		

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж (га)	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хрээнд өртөө зөрлөгүүдийн гадна талбайн тохижилт, ногоон байгууламж	Сухайн суулгац тариалах	Тавантолгой өртөө, 5 зөрлөг	багц	5,000	10000	50,000,000	Хавар, намар 2 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Нийт дүн						50,000,000		

БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Археологийн дурсгал Палеонтологийн дурсгал	Төмөр замын дагуух түүх соёлын өв бүхий хамгаалсан газруудыг сэргээн засварлах, орчны хог хаягдлыг цэвэрлэх	Гурван зээрдийн агуйн танилцуулга самбар хийх	1 удаа	700,000	700,000	2-оос доошгүй /шаардлагатай тохиодолд/	Соёлын өвийн тухай хууль
Нийт дүн					700,000		

БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1. БАЙГАЛИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР								

Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс төмөр замын хөдөлгөөн болон төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төмөр замын трасс дагууд болон төслийн талбай	сар	40,000	12	480,000	I-XII сард Гэрээний дагуу	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
Дүн						480,000		
2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР								
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Тавантолгой, Гашуунсухайт өртөө	сар/удаа	-	-	Үйл ажиллагааны зардалд		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн талбайд	-	-	-	Үйл ажиллагааны зардалд		
Дүн						480'000		
Нийт дүн						480'000		

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Өртөө зөрлөгүүдээс үүсэх ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	2 Өртөө, 6 зөрлөг	Сард	40'000	12 (Нийт 24 удаа/)	960'000	Хамтран ажиллах гэрээний дагуу /Сард 2 удаа Цогтцэций, Ханбогдруу/	Хог хаягдлын тухай хууль
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн бүх төрлийн байгууламжууд						БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний Өдрийн А/445 дугаар тушаал
								БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаал

Аюултай	Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх, стандартын дагуу байгуулсан агуулахад хадгалах, нийлүүлэгч талд буцаан өгөх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Вагон засварын төв, Машин механикмын үйлчилгээний үеийн хаягдал	Жилд	9'000'000	Хамтран ажиллах гэрээний дагуу хог хаягдал нийлүүлтээс хамаарна	БОАЖЯ-ын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/18 тушаал
	Тээвэрлэх үйлчилгээний хөлс					
Нийт дүн				9'960'000		

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР							
Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, NO ₂	Төмөр замын трассын дагуу 3 цэгт	Жилд 2 удаа буюу 4 болон 10 саруудад дээжлэлт хийх,	2 (Нийт 6 ш дээж)	100'000	600'000	Төмөр зам барих барилгын үйл ажиллагаа жигдэрсэн үед хэмжих	MNS 4585:2016), MNS 5919:2008 MNS 5013 :2001 MNS ISO 4221: 2002, MNS 5365:2004
Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5} Тоосны чөлөөт уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархалт	Төмөр замын трассын дагуу 2 байршилд	Жилд 2 удаа буюу 4 болон 10 саруудад дээжлэлт хийх	2 (Нийт 4 ш дээж)	100'000	400'000	Төмөр зам барих барилгын үйл ажиллагаа жигдэрсэн үед хэмжих	
Дүн					1'000'000		
2. ГАЗРЫН ДООРХ УС							
Ca, Mg, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , HCO ₃ , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт,	Төсөлд ашиглагдаж буй худгууд	Жилд 2 удаа дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	8	150'000	1'200'000	Төмөр зам барих барилгын үйл ажиллагаа жигдэрсэн үед хэмжих	MNS 0900:2005 (MNS 6148:2010) MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667 11:2000

үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин							MNS (ISO) 5667- 1:2002
Дүн					1'200'000		
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ							
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах. Хөрсний микроэлементийн үзүүлэлтүүд: Cd, Cr, Co, Cu, Pb, Mn, Ni, Zn.	Трассын дагуу 3 байршлын уурхай, засварын цэгүүдэд болон нөлөөлөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 3 цэгүүд (Цогтцэций сум, Баян-Овоо сум, Ханбогд сум)	Жилд 2 удаа буюу 4 болон 10 саруудад дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	3 (Нийт 6 ш дээж)	150'000	900'000	Барилгын ажлын үед хэмжих	MNS3297:1991 MNS:2305:1994 MNS:3298:1991
Дүн					900'000		
4. УРГАМЛАН НӨМРӨГ							
Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га	Трассын дагуу 3 байршилд болон нөлөөлөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 3 цэгүүд (Цогтцэций	Төмөр замын трассын дагуу 8 сард	Жилд 1 удаа (Нийт 6 дээж)	100'000	600'000	Төмөр зам барих барилгын үйл ажиллагаа жигдэрсэн үед хэмжих	Мониторингийн цэг бүрт судалгааг 25x 25 м ² талбайд 1 удаагийн давталттайгаар хийх

Ургамлын үрийн банк Ургамлын нягтшил 1м ² /бодгаль Тоосны тархал	сум, Баян-Овоо сум, Ханбогд сум)						
Дүн						600'000	
5. АМЬТНЫ АЙМАГ							
Төслийн ажиллагаанаас нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулах амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Тодорхой цэгүүдэд явуулын камер суурьлуулж зэрлэг ан амьтанд зориулсан гарц гармын оновцтой байдал, нүүдэл шилжилт хөдөлгөөний мэдээллийг цуглуулах арга хэмжээг авах	Төмөр замын трассын дагуу	-	-	-	Мэргэжлийн судлаачидтай хамтран ажиллах гэрээний дагуу	Амьтны тухай хууль MNS 6515 : 2015 (Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц)
Дүн						-	
						3'700'000	

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төмөр замын ашиглалтын явцад үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ. Зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг дор тусгав. (Хүснэгт)

Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын захиргаатай хамтран төмөр замд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх, тэднээс ажлын шаардлага хангасан иргэдийг ажлын байраар хангах	Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын иргэд	-	I-IV Улирал	Хүний нөөц, сургалтын хэлтэс
Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Гэрээт байгууллагаар хийлгэх	Дотоод үйл ажиллагааны зардлаас	1 удаа	Захиргаа, удирдлагын газар
Байгаль орчны мэдлэг дээшлүүлэх мэргэшүүлэх сургалтанд хамруулах /1-ээс доошгүй/	Байгаль орчин, орон нутгийн хэлтэс	Сургалтын зардлаас	1 удаа	Хүний нөөц, сургалтын хэлтэс, Байгаль орчин, орон нутгийн хэлтэс,

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Тавантолгой төмөр зам” ХХК нь “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх ба бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ. (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Зардал, төг
Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11-12 дугаар сард	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг дүгнүүлэх.	Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.	Үйл ажиллагааны зардлаас
Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, ИТХ-аар оруулж танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай (Тайлан мэдээ танилцуулга бэлтгэх)	Жил бүрийн 11-12 дугаар сард	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулах	Сумын төвд	Үйл ажиллагааны зардлаас

Багийн засаг дарга	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11-12 дугаар сард	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулах	Багийн төвд	Үйл ажиллагааны зардлаас
Нийт дүн						-